

## **ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Төрийн болон Орон нутгийн Өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6 дэх, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Мэдээллийн Технологийн үндэсний паркийн “Компьютер вишн лабораторийн үйл ажиллагааны журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. Дээрх журмыг 2014 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гурав. Батлагдсан тушаал /журам/-ын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Стратеги Бизнес Хөгжлийн Төвийн дарга /П.Наранцэцэг/ - т даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Б.МЯГМАРНАРАН

## **МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРКЫН КОМПЬЮТЕР ВИШН ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1. Мэдээллийн технологийн үндэсний паркийн Компьютер вишн лабораторид /цаашид “Компьютер вишн лаборатори” гэх/ үйл ажиллагаа зохион байгуулах хүсэлтэй хувь хүн хуулийн этгээдэд Компьютер вишн лабораторийг түрээслэх, түрээслүүлэх, хөнгөлөлттэй нөхцлөөр үйлчлүүлэх зарчмаар ашиглуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөн ажиллана
2. Лабораторийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь Компьютер вишн салбарыг хөгжүүлэх, оюуны мэдлэгийг дээшлүүлэх монгол контентыг хууль эрх зүйн дагуу боловсруулах, нийлүүлэхэд багш оюутан, хувь хүн, албан болон хувийн байгууллагыг дэмжин хамтран ажиллах, Компьютер график дээр суурилсан төрөл бүрийн үйл ажиллагаа явуулахад оршино.
3. Энэхүү журмыг Мэдээллийн технологийн үндэсний парк болон лабораторийг түрээслэн ашиглах болон ашиглаж буй хувь хүн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.
4. Лаборатори нь үйл ажиллагаандаа МТҮП-ын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, Иргэний хууль болон бусад холбогдох хүчин төгөлдөр хууль тогтоомжийг удирдлага болгон ажиллана
5. МТҮП нь энэхүү журмын дагуу түрээслэгчтэй түрээсийн гэрээ байгуулана. Гэрээ нь энэхүү журмын зүйл заалттай зөрчилдөхгүй байх шаардлагатай бөгөөд талуудын эрх үүргийг нарийвчлан тусгасан байна.

### **Хоёр. КОМПЬЮТЕР ВИШН ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛБЭР**

1. Лаборатори нь өөрийн чиг үүргийн хүрээнд дор дурьдсан үйл ажиллагааг явуулна. Үүнд:
  - График дизайн
  - Кино
  - Клип
  - Телевиз
  - Гэрэл зургийн студи
  - Видео студийн үйлчилгээ
  - Хэвлэлийн үйлчилгээ
  - Түрээсийн үйлчилгээ
  - Бусад бүх төрлийн үйл ажиллагааг зохион байгуулах
2. Лабораторийг хувь хүн, хуулийн этгээдэд түрээслүүлэх бөгөөд ийнхүү түрээслүүлэхдээ бартерийн гэрээний үндсэн дээр болон энэхүү журмын 4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр хөнгөлөлттэй түрээслүүлж болно.

3. Лабораторийн өдөр тутмын үйл ажиллагааг МТҮП-ын Өндөр технологи, хөгжлийн төв /цаашид “ӨТХТ” гэх/ хариуцан ажиллана.

4. Лабораторид зохион байгуулагдах үйл ажиллагааны хуваарийг захиалгын дагуу сар тутам МТҮП-ын ӨТХТ боловсруулж, Ерөнхий захирлаар батлуулна

#### **ГУРАВ: КОМПЬЮТЕР ВИШН ЛАБОРАТОРИЙН ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР, ТООЦОО**

1. Түрээстэй холбоотой төлбөр тооцоог МТҮП-ын Голомт банкны 1102099876 тоот дансанд урьдчилан шилжүүлнэ.
2. Түрээсийн төлбөр нь урьдчилсан төлбөрт байх бөгөөд түрээсийн төлбөрийг 100% төлж барагдуулсаны үндсэн дээр түрээслэх эрх үүснэ.
3. Үйл ажиллагаа явуулах захиалгыг 7 хоногийн өмнө авах бөгөөд хэрэв захиалга дүүрсэн байвал хүлээлгэнд бүртгүүлэх боломжтой.
4. Компьютер вишн лабораторийн нийт түрээсийн төлбөр нь цагт 250000₮ байна.

#### **ДӨРӨВ. ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ НӨХЦӨЛ**

4.1 Танхим ашиглах тохиолдолд:

4.1.1. МТҮП-тай арга хэмжээг хамтран зохион байгуулагчаар ажиллах бол төлбөрийн 50 хүртэл хувь

4.1.2. Инкубаторын компаниудад 80 хүртэл хувь

4.2 Танхим болон тоног төхөөрөмж ашиглах тохиолдолд:

4.2.1. Шинжлэх ухаан танин мэдэхүйн нэвтрүүлэг, анимэйшн бэлтгэх зорилгоор танхим болон тоног төхөөрөмж ашиглах бол төлбөрийг 80% хөнгөлнө.

4.2.2. 30-аас дээш цагийн үйл ажиллагаа зохион байгуулах тохиолдолд нийт үнийн дүнгээс 30% хүртэл хөнгөлөлт үзүүлнэ.

4.3. Зөвхөн тоног төхөөрөмж ашигласан бол

4.3.1 Лабораторид Зөвхөн Тоног төхөөрөмж ашиглах бол түрээсийн үнийн 70% хүртэл

Үүнд.

- Видео камера
- Монтажны компьютер
- Ажлын эффект боловсруулах компьютер
- Энгэрийн утасгүй микрофон
- Чихэвч
- Видео пульт, converter, мониторинг дэлгэц

4.4. Тоног төхөөрөмжийг МТҮП-ын байрнаас гадуур ашигласан бол; /Тоног төхөөрөмжийг гадуур авч хэрэглэхийн өмнө тоног төхөөрөмжийн үнийн жагсаалт болон ашиглалтын талаарх заалтыг хавсралтаас үзэх/

4.4.1 Нийт түрээсийн үнэтэй дүйцэхүйц барьцаа төлбөр байршуулах

4.4.2. Тоног төхөөрөмжийг түрээслэхийн өмнө албан байгууллага бол албан бичиг байгууллагын гэрчилгээ, хувь хүн бол өргөдөл болон баталгаажсан бичиг баримтыг өгсөн байх

4.4.3. Тоног төхөөрөмжийг гэмтээх, зөвшөөрөлгүй засварлах, алга болгосон тохиолдолд тухайн төхөөрөмжийн үнийн дүнг хавсралтад заагдсан ханшийн дагуу бүрэн гүйцэд төлж, барагдуулна.

4.5. Онцгой тохиолдолд МТҮП-ын Ерөнхий захирлын зөвшөөрлөөр тоног төхөөрөмж болон танхимаар хангах үйлчилгээг үзүүлж болно

4.6. МТ-ийн салбарыг хөгжүүлэх хүний нөөцийг чадавхижуулахтай холбоотой онол практикийн хурал, хэлэлцүүлэг, техник технологийн танилцуулга үзэсгэлэн, шинэлэг бүтээлч санаа, сургалт семинар зохион байгуулах тохиолдолд харъяалагдах нэгжийн даргын зөвшөөрлөөр танхим болон тоног төхөөрөмжөөр хангах үйлчилгээг үзүүлнэ.

#### **ТАВ. КОМПЬЮТЕР ВИШН ЛАБОРАТОРИЙН АЖИЛЛАХ ЦАГИЙН ХУВААРЬ**

5.1 Компьютер вишн лабораторийг МТҮП-ын ӨТХТ-ийн мэргэжилтэн хариуцан ажиллана.

5.2 Даваа-Баасан гарагуудад 8-17 цаг хүртэл ажиллана. Хэрэв тухайн байгууллага хүсэлт гарган, ажлын бус цаг, амрралтын өдрүүдэд үйл ажиллагаа зохион байгуулсан тохиолдолд тухайн өдөр ажиллаласан мэргэжилтний илүү цагийн мөнгийг түрээсийн үндсэн төлбөр дээр нэмж олгох буюу тохиролцоно.